


Хувилбар В

1.гэдэг нь нийгмийн тодорхой хэрэгцээг хангахад чиглэсэн үүрэг, статусын цогц. Зөв хариултыг сонгоно уу? 1 оноо
 a. Нийгмийн тогтолцоо b. Нийгмийн харилцаа c. Нийгмийн бүтэц d. Нийгмийн хандлага e. Нийгмийн институт
2. Бараа үйлчилгээний үйлдвэрлэл, хуваарилалт, хэрэглээг хангах, хязгаарлагдмал хомс нөөц баялгаар хязгааргүй хэрэгцээг хангах нь нийгмийн аль институтын үүрэг вэ? 1 оноо
 a. Гэр бүлийн b. Боловсролын c. Эдийн засгийн d. Улс төрийн e. Шашны
3. Сонгуульд оролцож, саналаа өгөхийн төлөө тэмцэж байсан эмэгтэйчүүдийг дорд үзэж, улмаар хорих, шийтгэх, янз бүрийн нэр хоч өгч байсан нь өнөөгийн ардчиллын өнцгөөс харвал хэм хэмжээг зөрчсөн үйлдлийн ямар төрөлд хамаарагдахыг олж тэмдэглэ. 3 оноо
 a. Албан ёсны хяналт b. Нийгмийн хяналт c. Гэмт хэрэг d. Албан бус хяналт e. Нийгмийн гажуудал
4. Нийгэм нь нийгэм эдийн засгийн нөөц баялгийн төлөө өөр хоорондоо өрсөлдөгч бүлгүүдээс тогтдог гэж үздэг онолын хандлага аль вэ? 1 оноо
 a. Харилцан үйлдлийн онол b. Бүтэц чиг үүргийн онол c. Зөрчилдөөний онол d. Нийгмийн онол e. Шалтгаант чанарын онол
5. Нийгмийн амьдралд үндсэн эргэлт гаргадаг, харьцангуй хурдтай, чанарын гүнзгий өөрчлөлтийг юу гэж нэрлэдэг вэ? 1 оноо
 a. Дэвшил b. Хувьсал c. Шинэчлэл d. Хувьсгал e. Ухралт
6. Энгийн хөдөлмөрийн багаж зэвсэг ашиглан тариалангийн аж ахуй эрхэлдэг ч нэмүү өртөг бүтээх түвшинд хүрээгүй, ураг төрлийн холбоонд суурилсан, олон төрлийн овгуудаас тогтох нийгэм бол.....юм. 1 оноо
 a. Мал аж ахуйн нийгэм b. Ан агнуурын нийгэм c. Аж үйлдвэржсэн нийгэм d. Аж үйлдвэржсэний дараах нийгэм e. Цэцэрлэг аж ахуйн нийгэм
7. Нийгмийн давхраажилтын хэв маягуудад аль нь хамааралгүй вэ? 1 оноо
 a. Эд баялаг b. Боолчлол c. Язгуур d. Каст e. Анги
8. Нийгмийн давхраажилтын марксист онолын хандлагын суурь ойлголт аль нь вэ? 1 оноо
 a. Эд баялаг b. Статус c. Нэр хүнд d. Эрх мэдэл e. Анги
9. Нийгмийн давхраажилтын талаар М.Веберийн онолын суурь ойлголтуудаас илүүц зүйл дурдсан бол аль нь вэ? 2 оноо
 a. Эрх мэдэл b. Нэр хүнд c. Эд баялаг d. Хүсэл тэмүүлэл e. Хөрөнгө мөнгө
10. Давхраажилтын дараах хэмжигдэхүүнээс эрх мэдлийн төрөлд аль нь хамаарах вэ? 1 оноо
 a. Үл хөдлөх хөрөнгө эзэмших b. Бусдад нөлөөлөх, дагуулах c. Хөдөлмөрийн зах зээл дэх эрэлт, үнэ цэнэ d. Онцгой авьяас чадвар e. Язгууртан угсаатан байх
11. “Соёлын үнэт зүйл гэдэгт эх хэл, бичиг үсэг, уламжлалт технологи, газар усны нэр, зан заншил, бэлгэ тэмдэг, ном судар, шашдир болон соёл судлалын бүтээл хамаарна” гэж ямар хуульд заасан бэ? 2 оноо
 a. Монгол улсын Хөдөлмөрийн тухай хуульд b. Монгол улсын Үндэсний аюулгүй байдлын тухай хуульд c. Монгол улсын Соёлын тухай хуульд d. Монгол улсын Боловсролын хуульд e. Монгол улсын Үндсэн хуульд
12. Нийгмийн цөөнх болон язгууртан дээд давхрааны төлөөлөгчдөд зориулагдан тэдний захиалгаар бий болсон соёлыггэнэ. 1 оноо
 a. Сөрөг соёл b. Ардын соёл c. Нийтийн соёл d. Дагуул соёл e. Элитийн соёл
13. Соёлын босоо чиглэлийн ангилалд илүүц зүйл дурдсан бол аль нь вэ? 1 оноо
 a. Ардын соёл b. Элитийн соёл c. Соёлын эрх чөлөө d. Нийтийн соёл e. Зонхилогч соёл
14. Соёлын салбарт хүний нөөцийн чадавхийг бэхжүүлэх, соёлын үйлдвэрлэл эрхлэх таатай нөхцөл бүрдүүлэх, улс үндэстнийхээ соёл, өв уламжлал, байгалийн өвөрмөц төрхийг эдийн засгийн эргэлтэнд оруулах, түүнийг дэлхийд сурталчлах зорилгыг эн тэргүүндээ тавьсан хөтөлбөр аль нь вэ? 1 оноо
 a. Уламжлалт соёл b. Соёлын бодлого c. Үндэстний соёлын онцлог d. Монгол өв соёл e. Соёлын үйлдвэрлэл
15. Соёлын үйлдвэрлэлийг нэрлэхдээ илүүц зүйл дурдсан бол аль нь вэ? 3 оноо
 a. Бүтээлч шинэ эдийн засаг b. Соёлын орон зай c. Утаагүй үйлдвэрлэл d. Соёлд суурилсан бүтээлч үйлдвэрлэл e. Чөлөөт цагт зориулсан үйлдвэрлэл /шоу бизнес/
16.нь орчин үед угсаатны соёл, соёлын философи, соёлын эдийн засаг, соёлын газарзүй, соёлын сэтгэл зүй, соёлын экологи гэх мэт салбаруудыг хамаарна. 1 оноо
 a. Оюуны соёл b. Эдийн соёл c. Соёл судлал d. Хэрэглээний соёл e. Материаллаг соёл
17. Хүн бүрийн өвөрмөц онцлогийг хүлээн зөвшөөрч, тэр бүрийг хөгжүүлэхээр тэмцэнэ гэдэг хүмүүний соёлын хөгжлийн үнэт ололт яах аргагүй мөн гэсэн нь хэний үзээл вэ? 1 оноо
 a. К.Маркс b. Ж.Локк c. М.Вебер d. Э.Фромм e. Н.Макиавелли
18. Соёлын эрх чөлөөний суурь зарчмуудад хамааралгүйг олж тэмдэглэнэ үү. 1 оноо
 a. Соёлын сонголт хийх бололцоог өргөжүүлэх b. Соёлын тэгш байдлыг үнэлэх c. Уламжлалт ёс заншлыг хадгалах d. Соёлын тулгалт хийх e. Угсаатны ялгаатай бүлгүүд болон нутгийн уугуул иргэдийн соёлыг хүндэтгэх
19. ДНБ-ийг тогтмол үнээр тооцсоныг юу гэж нэрлэдэг вэ? 1 оноо

Элсэлтийн ерөнхий шалгалт -2019 он

- a. Зах зээлийн b. Нэрлэсэн ДНБ c. Байнгын d. Тогтмол e. Бодит ДНБ
20. ДНБ-ийг орлогоор тооцоход хамааралгүй зүйл оруулсан бол аль нь вэ? 1 оноо
a. Зээлийн хүүгийн орлого b. Цалин, түрээсийн орлого c. Үндсэн хөрөнгийг элэгдэл d. Хувь хүн орлого e. Шууд бус татварын орлого
21. Ямар нэг компанийн өмчийн тодорхой хэсгийг эзэмшиж буйг гэрчилсэн баримтыг.....гэнэ. 1 оноо
a. Бонд b. Хувьцаа c. Хадгаламж d. Хуримтлал e. Лиценз
22. Макро эдийн засгийн бодлогын зорилго аль нь вэ? 1 оноо
a. Эдийн засгийн уналтыг зогсоох, инфляцийг сааруулах b. Улс төрийг тогтвортой байлгах, ажлын байр нэмэгдүүлэх c. Татварын хувь хэмжээг багасгах, гадаадаас зээл тусламж гуйх d. Гадаадын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, олон намын тогтолцоотой байх e. Иргэдээ чадавхжуулах, урт хугацаатай хүү багатай зээл олгох
23. Өндөр хурдтай инфляцийн үед хэн хожиж болох вэ? 2 оноо
a. Үндсэн хөрөнгө худалдан авч байгаа хүмүүс b. Үндсэн хөрөнгөө худалдаж байгаа хүмүүс c. Зээлээ төлж байдаг хүмүүс d. Банкинд хадгаламжтай хүмүүс e. Тэтгэвэр, тэтгэмж авч байгаа хүмүүс
24. Гүйлгээнд мөнгө нэмж оруулах буюу мөнгөний нийлүүлэлтийг нэмэгдүүлэх бодлогыг ямар бодлого гэх вэ? 1 оноо
a. Мөнгөний тэлэх b. Мөнгөний хумих c. Засгийн газрын d. Сангийн яамны e. Эдийн засгийн
25. Доор дурдсан шийдвэрүүдээс аль нь инфляцийн эсрэг бодлогод хамаарах вэ? 3 оноо
a. Мөнгөний нийлүүлэлтийг нэмэх b. Банкны зээлийн хүүг бууруулах c. Банкинд байгаа хадгаламжуудыг индексжүүлэх d. Татварын хувь хэмжээг өсгөх e. Засгийн газраас бонд гаргаж худалдах
26. Улс орнуудын хооронд бараа, үйлчилгээ шилжих хөдөлгөөнийг.....гэнэ. 1 оноо
a. Олон улсын худалдаа b. Гадаад худалдаа c. Гадаадын хөрөнгө оруулалт d. Гадаадын зээл тусламж e. Экспорт, импорт
27. Эдийн засгийн хөгжлийн үзүүлэлтүүдэд хамааралгүйг олно уу? 1 оноо
a. Чадварлаг бүтээлч иргэд b. Амьжиргааны түвшин дээшилж, эдийн засаг өссөн c. Ажилгүйдэл, ядуурал буурсан d. Эдийн засаг тогтворгүй өссөн e. Үйлдвэрлэлийн салбар хумигдаж, эдийн засгийн бүтээмж буурсан
28. Хүмүүнлэг, иргэний, ардчилсан нийгэм цогцлуулан хөгжүүлэх зорилгын томъёололд ороогүйг ялгаж олоорой. 2 оноо
a. Хүн төрөлхтний соёл иргэншлийн ололтыг хүндэтгэх үзэх b. Улсынхаа тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлыг бататган хөгжүүлэх c. Хүний эрх, эрх чөлөө, шударга ёс, үндэснийхээ эв нэгдлийг эрхэмлэн дээдлэх d. Байгаль орчноо хамгаалах e. Төрт ёс, түүх, соёлынхоо уламжлалыг нандигнан өвлөх
29. Хууль тогтоох засаглал буюу парламент, шүүх-арми гэсэн бүтэцтэй гүйцэтгэх засаглал, хаан сайд нар багтдаг байгууллага буюу холбооны засаглалын ангилал хийсэн сэтгэгчийг нэрлэнэ үү. 1 оноо
a. Ж.Локк b. Ш.Монтескье c. Н.Макиавелли d. К.Маркс e. М.Вебер
30. Иргэний нийгмийг юу гэж ойлгож болох вэ? 1 оноо
a. Хүмүүсийн аяндаа гаргасан үйл ажиллагааны үр дүн b. Ёс суртахууны үндсийг бий болгох явдлын үр дүн c. Иргэд төрийг хянаж, төрд хариуцлага хүлээлгэж чаддаг хүмүүсийн нэгдлийг d. Хүмүүсийн бие биетэйгээ эвлэлдэн нэгдэх явдал e. Хүмүүсийн үйл ажиллагааны чиг хандлага
31. Иргэний нийгмийн үндсэн шинжид аль нь хамаарахгүй вэ? 1 оноо
a. Хүний эрх, эрх чөлөөг дээдлэх b. Нийгмийн бүх асуудлыг төрийн оролцоотойгоор шийдвэрлэх c. Зах зээлийн эрүүл саруул тогтолцоог хөгжүүлэх d. Мэдээллийн хэрэгслийн эрх чөлөө e. Иргэдийн нийгмийн идэвх дээшлэх
32. Сонгогч гэж хэнийг хэлэх вэ? 1 оноо
a. Хорих ял эдэлж буй иргэн b. Аль нэг намын гишүүн c. 25 насанд хүрсэн иргэн d. Гадаадын харьяат иргэн e. Сонгуулийн эрх бүхий иргэн
33. Намын нэрээр санал хурааж, авсан саналд нь хувь тэнцүүлж суудал хуваарилдаг сонгуулийн тогтолцоо аль нь вэ? 1 оноо
a. Чөлөөт сонгууль b. Холимог c. Пропорцианоль d. Мажоритар e. Уламжлалт
34. Нийтлэл нэвтрүүлгийн тусламжтайгаар үнэн бодитой мэдээллээр шуурхай, тогтмол хангах зорилго бүхий тогтмол хэвлэл радио, телевиз, мэдээллийн агентлаг, баримтат кино, цахим хэвлэл зэргийг...гэнэ. 1 оноо
a. Хэвлэл мэдээлэл b. Хэвлэлийн эрх чөлөө c. Өдөр тутмын хэвлэл d. Олон нийтийн телевиз e. Олон нийтийн радио
35. Ардчилсан нийгэмд хэвлэл мэдээллийн баримтлах зарчмуудыг тоочихдоо илүүц зүйл оруулсныг ялгаж тэмдэглэнэ үү. 3 оноо
a. Олон түмний эрх ашгийн төлөө үнэн зөв мэдээлэл дамжуулах b. Ард түмний дуу хоолой болох c. Нас хүйс, шашин шүтлэг, боловсролын түвшин харгалзахгүйгээр мэдээллийг бүх нийтиэд тэгш хүргэх боломжийг нь хуулиар хангах d. Улс төрийн аль нэг намын байр суурийг илэрхийлэгч байх e. Хэвлэл мэдээллийн ажилтнууд болон сэтгүүлчдийн эрх ашгийг хамгаалах
36. Д.Истоны улс төрийн системийн загварыг нөхөж гүйцээнэ үү. 1 оноо



- a. А. дэмжлэг Б. шаардлага В. шийдвэр Г. үйлдэл
 - b. А. зөвшилцөл Б.дэмжлэг В.шийдвэр Г. үр дүн
 - c. А. шаардлага Б. дэмжлэг В. шийдвэр Г. үйлдэл
 - d. А. шийдвэр Б. үйлдэл В. Шаардлага Г. Зөвшилцөл
 - e. А. үйлдэл Б. дэмжлэг В. шийдвэр Г. шаардлага
37. Хүний эрхэм чанарын үндсэн шинжүүдэд илүүц зүйл оруулсан бол аль нь вэ? 1 оноо
- a. Хүний эрхэм чанар нь үл хэмжигдэх үнэт зүйл b.Хүний эрхэм чанар нь хүн бүрт адилхан байх c.Хүнээс хүний эрхэм чанарыг нь салгаж болохгүй d. Хүний эрхэм чанарт халдаж болохгүй e. Хүний эрхэм чанар хүн бүрт ялгаатай байх
38. НҮБ нь хэдэн онд байгуулагдсан бэ? 1 оноо
- a. 1950 он b. 1948 он c. 1961 он d. 1945 он e. 1952 он
39. Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр тэтгэмжийн хуульд зааснаар “тэтгэвэрийн даатгалын сангаас даатгуулагчид олгох тэтгэвэр нь: , , тэтгэвэр” гэсэн төрөлтэй байдаг. 1 оноо
- a. Хөдөлмөрийн чадвар түр алдсаны, жирэмсний, өндөр насны b. Өндөр насны, тахир дутуугийн, тэжээгчээ алдсаны c. Ажилгүйдлийн, өндөр насны, тахир дутуугийн d. Тэжээгчээ алдсаны, ажилгүйдлийн, жирэмсний e. Оршуулгын, тахир дутуугийн, тэжээгчээ алдсаны
40. Хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмжийг ямар нөхцөлд олгох вэ? 2 оноо
- a. Даатгуулагч нийгмийн даатгалын шимтгэлийг 3 болон түүнээс дээш сарын хугацаагаар төлсөн тохиолдолд тэтгэмж авах эрх үүснэ.
 - b. Даатгуулагч нийгмийн даатгалын шимтгэлийг 6 болон түүнээс дээш сарын хугацаагаар төлсөн тохиолдолд тэтгэмж авах эрх үүснэ.
 - c. Даатгуулагч нийгмийн даатгалын шимтгэлийг 12 болон түүнээс дээш сарын хугацаагаар төлсөн тохиолдолд тэтгэмж авах эрх үүснэ.
 - d. Даатгуулагч нийгмийн даатгалын шимтгэлийг 5 болон түүнээс дээш сарын хугацаагаар төлсөн тохиолдолд тэтгэмж авах эрх үүснэ.
 - e. Даатгуулагч нийгмийн даатгалын шимтгэлийг 7 болон түүнээс дээш сарын хугацаагаар төлсөн тохиолдолд тэтгэмж авах эрх үүснэ.
41.нь зөвхөн Үндсэн хууль зөрчсөн талаар маргааныг шийдвэрлэж, хуульд заасан тодорхой байгууллага, албан тушаалтны шийдвэр үйл ажиллагаа үндсэн хуульд нийцэж байгаа эсэхэд хяналт тавьдаг. 2 оноо
- a. УИХ b. Үндсэн хуулийн цэц c.Засгийн газар d.Намууд e. Шийдвэр гаргах түвшний албан тушаалтнууд
42. Баялгийн үр шимийг хүртэх, баялгийг бүрэн хараа хяналтандаа байлгах, баялгийг худалдах, бэлэглэх, арилжир, зээлэх зэрэг эрх нь эдийн засгийн ямар эрхэд хамаарах вэ? 1 оноо
- a. Ёс суртахууны эрх b. Хүний эрх c. Хөдөлмөрлөх эрх d. Өмчлөх эрх e. Иргэний эрх
43. Хуульд заасан гэм буруутай бүх үйлдэл, эс үйлдлийг эрх зүйн зөрчил гэж хэлдэг. Эрх зүйн зөрчлийг хэрхэн ангилдаг вэ? 1 оноо
- a. Хохирол, хор уршиг b. Гэм хор, хор уршиг c. Гэмт хэргийн ба гэмт хэргийн бус d. Хор уршиг, гэмт үйлдэл e. Ёс суртахууны доройтол
44. Бусдын эд хөрөнгийг хулгайлсан үйлдэл нь эрүүгийн гэмт хэргийн шинж агуулаагүй, хохирол багатай бол ямар зөрчилд тооцогдох вэ? 3 оноо
- a. Зохиогчийн эрхийг зөрчих b. Захиргааны зөрчил c. Хүүхдийн эрхийг зөрчих d. Сахилгын зөрчил e. Эд хөрөнгийн зөрчил
45. Захиргааны хэргийг урьдчилан шийдвэрлэх ажиллагаанд хэргийн оролцогч этгээдийг тоочихдоо илүүц зүйл оруулсан бол аль нь вэ? 1 оноо
- a. Туслах чиг үүрэгтэй оролцож буй этгээд b. Гомдол гаргаж буй иргэн ба хуулийн этгээд c.Хариуцагч болох захиргааны байгууллага, албан тушаалтан d. Гуравдагч этгээд e. Дүүргийн засаг дарга
46. Иргэн хүн захиргааны байгууллагатай харилцан үндсэн хэлбэрийг тоочихдоо илүүц зүйл оруулсан бол аль нь вэ? 3 оноо
- a. Гомдол мэдүүлэх b. Өргөдөл гаргах c. Нотлох баримт гаргах, шалгуулах d. Хүсэлт гаргах e. Санал гаргах
47. Монгол улсын гадаад бодлогын чиглэлд хамааралгүй зүйлийг тэмдэглэнэ үү. 1 оноо

Элсэлтийн ерөнхий шалгалт -2019 он

- а. Үзэл суртал, суртал нэвтрүүлгийн б. Эдийн засаг, бизнесийн с. Соёл, хүмүүнлэгийн д. Улс төр, дипломатын е. Шинжлэх ухаан, технологийн
48. Монгол улс гадаад бодлогынхоо хүрээнд нутаг дэвсгэрээ цөмийн зэвсэггүй бүс болгон зарласан оныг олж тэмдэглэ. 1 оноо
а. 2000 он б. 1914 он с. 1916 он d. 1992 он e. 2011 он
49. Монгол улсын гадаад бодлогын эн тэргүүний зорилтыг олно уу. 1 оноо
а. ОХУ, БНХАУ-тай найрсаг, сайн хөршийн хамтын ажиллагааг хөгжүүлэх б. Ази номхон далайн улс орнуудтай харилцах с. АНУ ба өрнөдийн хөгжингүй орнуудтай харилцах d. Посткоммунист орнуудтай харилцах e. Дэлхийн бүх орнуудтай харилцаж хамтын ажиллагаа өрнүүлэх
50. Монгол улсын эдийн засгийн гадаад харилцааны олон талт үйл ажиллагааны салбарт хамааралгүйг олно уу? 1 оноо
а. Гадаадын зээл тусламж б. Бизнес, аж ахуйн хамтын ажиллагаа с. Гадаад худалдаа, хөрөнгө оруулалт d. Аялал жуулчлал e. Парламент хоорондын харилцаа
51. Монгол улсын гадаад бодлогын голлох бүс нутаг, улс орныг тоочихдоо илүүц зүйл оруулсан бол аль нь вэ? 2 оноо
а. Төв Африкийн орнууд б. Хойд Америк ба Европын улс орнууд с. Төв Азийн улс орнууд буюу, тусгаар улсуудын хамтын нөхөрлөл d. Зүүн хойд Азийн бүс нутаг /ОХУ, БНХАУ, Солонгос, Япон г.м/ e. Зүүн өмнөд Азийн бүс нутаг
52. Монгол улсын гадаад бодлогын үзэл баримтлалд улс бус оролцогчидтой харилцах тулгуур чиглэлд хамаарахгүй нь аль нь вэ? 2 оноо
а. Ази номхон далайн эдийн засгийн хамтын ажиллагаа /АПЕК/ б.Хөрш орнуудтай найрсгаар тэнцвэртэй харилцах с. Зүүн өмнөд Азийн бүс нутгийн хамтын ажиллагааны нийгэмлэг /АСЕАН/ d. Эвсэлд үл нэгдэх хөдөлгөөн e. НҮБ болон түүний төрөлжсөн байгууллагууд, тусгаар улсуудын хамтын нөхөрлөл
53. Ард түмэн олон улсын харилцаанд яаж оролцдог вэ? 1 оноо
а. Хараар /хууль бусаар ажиллаж амьдрах/ б. Гадаад гарч ажиллаж амьдрах с. Гадаадын пүүс, компани, ААН-тэй гэрээ хийснээр d. Хувийн шугамаар e. Өөрийгөө төлөөлөх тодорхой байгууллагаар дамжуулан
54. Монгол улс гуравдагч хөрштэйгээ хэзээнээс дипломат харилцаа тогтгож ирснийг зөв холбоно уу. 3 оноо
- | | | | |
|---|-----------------------------------|---|----------|
| a | Монгол улс ба Турк улсын харилцаа | 1 | 1972 онд |
| b | Монгол улс ба БНСУ-ын харилцаа | 2 | 1969 онд |
| c | Монгол улс Япон улсын харилцаа | 3 | 1990 онд |
- а. А3 В2 С1 б. А2 В3 С1 с. А3 В1 С2 d. А1 В3 С2 e. А2 В1 С3
55. Зөөлөн хүчний бодлогын төрлүүдээс хамааралгүй зүйлийг олно уу? 1 оноо
а. Зорилгыг өөрчлөн чиглүүлэх б. Сэтгэл татах чадвар с. Албадлага d. Үнэмшил, тогтолцоо e. Үнэт зүйлс, соёл, төрийн бодлого
56. Соёлын, эдийн засгийн, хүмүүнлэгийн, цахим, дипломат үйл ажиллагааны хэлбэрүүд гадаад бодлогын аль чиглэлд хамаарагдах вэ? 3 оноо
а. Цэргийн хүч, эдийн засгийн хориг б. Хатуу хүчний бодлого с. Гурав дахь хөршийн бодлого d. Олон улсын эрх зүй e. Зөөлөн хүчний бодлого

Санамж:

1. Энэ хэсэг сонгох даалгавар биш тул харгалзааг зөв тогтоож хариуг бөглөөрэй.
2. Зөв харгалзуулсан хариулт бүр 1 оноотой.

2.1 Нийгмийн хэлбэрүүдийг зөв харгалзуулна уу? /5 оноо/

a	Аж үйлдвэржсэний дараах нийгэм	1	Хувийн өмчгүй, нийтийн өмчид суурилсан дарлал мөлжлөггүй нийтээрээ эрх тэгш амьдрах нөхцөлөөр хангагдсан нийгмийн байгууллын төгс дээд хэлбэр гэж томъёолдог.
b	Уламжлалт нийгэм	2	Эрчим хүч үйлдвэрлэлийн технологи нь нийгмийн хөгжилд гол үүргийг гүйцэтгэдэг.
c	Аж үйлдвэржсэн нийгэм	3	Эрх чөлөөтэй иргэд өвөрмөц сонирхолоороо нэгдэн нийлсэн, төрийн үйл ажиллагааны гадна эрх тэгшээр сонирхолоо хэрэгжүүлэх гэсэн нийгмийн бүлгүүдийн нэгдэл холбоо
d	Иргэний нийгэм	4	Шинжлэх ухаан боловсролын үйлчилгээ хөгжиж, автоматчилал, компьютер, мэдээллийн технологийг ашигладаг.
e	Коммунист нийгэм	5	Ураг төрлийн харилцаа давамгайлсан, хөдөлмөрийн хуваарийн түвшин дорой, хамтын өмчид суурилсан удирдлагын болхи системтэй, ёс заншил, зан үйлийг тулгуур болгосон том биш нийгэм

2.2 Соёлын хэлбэрүүдийг зөв харгалзуулна уу? /5 оноо/

a	Элитийн соёл	1	Нийгмийн бүхий л давхаргад хүртээмжтэй болсон
b	Ардын соёл	2	Нийгмийн цөөнх буюу дээд хэсгийнхний захиалгаар мэргэжлийн хүмүүс бий болгосон
c	Соёл	3	Зонхилогч соёлоос ялгарч ноёлогч үнэлэмжүүдтэй зөрчилдөж байдаг соёл
d	Сөрөг соёл	4	Хүний бүтээсэн болон бүтээж байгаа, хүн өөрийгөө хүн болгон төлөвшүүлэх эд өлгийн болон оюун үнэт зүйлсийн цогцолбор
e	Нийтийн соёл	5	Тухайн улс орон дахь ард олны нийтлэг итгэл, үнэмшил, загвар хэм хэмжээг тодорхойлох

2.3 Мөнгө, мөнгөний үүргүүдийг зөв харгалзуулна уу? /5 оноо/

a	Төлбөрийн хэрэгсэл	1	Мөнгө бүх төрлийн бараа, үйлчилгээнд хөрвөх чадвартай
b	Гүйлгээний хэрэгсэл	2	Бараа үйлчилгээний чанар, үнэ цэнийг харьцуулах, жишихэд
c	Мөнгө	3	Бараа болон үйлчилгээний төлбөр гүйцэтгэхэд ашиглагдах
d	Өртгийн хэмжүүр	4	Мөнгөөр бүх бараа үйлчилгээг худалдан авч болдог учир ямар ч төрлийн төлбөрийг хийж болдог
e	Хуримтлалын хэрэгсэл	5	Бараа үйлчилгээг хоорондоо солилцохдоо хэрэглэхээр бүх нийтээрээ хүлээн зөвшөөрсөн онцгой төрлийн таваар

2.4 Улс төрийн намуудын хэлбэрүүдийг зөв харгалзуулна уу? /5 оноо/

a	Зүүн нам	1	Төрийн нийгмийн бодлогыг хязгаарлах чиглэлтэй хувийн өмчтөн, бизнес эрхлэгчид дунд ангийн эрх ашгийг хамгаалдаг
b	Кокус нам	2	Албан ёсны гишүүнчлэлтэй, шаталсан зохион байгуулалтын бүтэцтэй, сонгуулийн бус үед ч идэвхтэй үйл ажиллагаа явуулдаг, гишүүд нь намынхаа ажилд байнга оролцох учиртай
c	Олон түмний нам	3	Хатуу гишүүнчлэлгүй, сонгуулийн үеэр идэвхтэй үйл ажиллагаа явуулах чадамжтай, намын байгууллага нь ихээхэн чөлөөтэй ажиллах боломжтой.
d	Барууны нам	4	Төрийн нийгмийн бодлого явуулах чиглэлтэй, ядуу хэсгийн хэсгийн эрх ашиг, бүх нийтийн тэгш ёсыг хамгаалдаг
e	Боловсон хүчний нам	5	Намын үндсэн ажлыг цөөн бүлэг хүмүүс, намын лидерүүд эрхэлдэг ба тэд намынхаа бодлогын асуудлыг шийдвэрлэж байдаг.